



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Хүний хөгжил сангийн төсвийн багцын
2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/18/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот
2015 оны 4 дүгээр сар



ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Сугармаа
Утас: 263703
Цахим хаяг:
sugarmaats@ audit.gov.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-САГ/2015/18/СТА-ТЕЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 6-наас 2015 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөж Үндэсний аудитын газрын САГ-ын 1 дүгээр багийн ахлах аудитор Ц.Сугармаа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дугаар сарын 3-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 6-наас 2015 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 4 дүгээр сарын 25-нд Сангийн сайдад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Хүний хөгжил сангийн тухай болон Монгол Улсын Төсвийн тухай, Халамжийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын

санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 20.1, 20.2 дахь зүйлд заасан үндэслэл, шаардлагын дагуу Хүний хөгжил сангийн 2014 оны санхүүгийн тайланг гаргасан байна.

Хүний хөгжил сангийн тухай хууль 2009 онд батлагдсан бөгөөд эрдэс баялгийн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор Хүний хөгжил санг байгуулжээ.

Монгол Улсад олон улсын жишигт нийцсэн баялгийн сангийн тогтолцоог бий болгох, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр 2014 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан байна. Энэхүү хуулийн төслийн зорилго нь эрдэс баялгийн салбарын орлогоос ирээдүй хойч үедээ тэгш хүртээх, байгалийн шавхагдах нөөцийг байнгын өсөн нэмэгдэх санхүүгийн хуримтлалд шилжүүлэх замаар ирээдүй хойч үеийхэндээ өвлүүлэх, одоогийн Хүний хөгжил сангийн үйл ажиллагааг өөрчилж, ирээдүйн хуримтлалын сан байгуулах зорилгыг тодорхойлсон байна.

Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас санхүүжилтийн эрх олгосноор Төр хариуцах иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл, Засгийн газрын бондын хүүгийн төлбөр, Урьдчилгаа төлбөрийн зээлийн хүү болон 0-18 насны хүүхэд бүрт сар бүр олгох 20.0 мянган төгрөгийн санхүүжилтийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хүний хөгжил сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хүний хөгжил сангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг данс бүрээр түүвэрлэн гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Санхүүгийн тооцоолох ХХК-ийн РТreasury програмыг ашиглаж, санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хийж байна.

Тус сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Материаллаг түвшинг тус сангийн нийт санхүүжилтийн гүйцэтгэлээс 1 хувиар тооцож, 2.3 тэрбум төгрөгөөр тогтоов.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Аудитаар Хүний хөгжил сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилах зэргээр гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулиар нийт 549.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 419.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 130.7 тэр бум төгрөг буюу 76.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь олон улсын зах зээл дээрх гол нэрийн ашигт малтмалын үнэ буурсан, түүнчлэн дотоодын нүүрсний борлуулалт болон нүүрсний үнэ тонн тутамд 40 хувиар, төмрийн хүдэр 8.0 сая тонноос 5.0 сая, алтны роялтийн татвар оны эхэнд 9 хувь байсныг 2.5 хувь болж тус тус буурснаас шалтгаалжээ.

2014 онд хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж, төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын хураамж болон зээлийн үйлчилгээний төлбөрт улсын төсвөөс 318.4 тэрбум төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 312.4 сая төгрөгийг авч, төсвийг 6.0 тэр бум төгрөгөөр хэмнэжээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оны нийт төсөв болон эхний 4 сарын байдлаар хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжид 81.0 тэрбум төгрөг, төр хариуцах эрүүл мэндийн даатгалд 4.0 тэр бум төгрөг олгожээ. ХХС-гийн төсвийн гүйцэтгэлийг сангийн яамны шилэн дансны мэдээлэлд байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын данс бүрээр эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил хийж дүгнэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үлдэгдлээр илэрхийлэгдсэн авлага 108.5 тэрбум төгрөг, өр 814.9 тэрбум төгрөг нийт 923.4 тэрбум төгрөгийг үүссэнээс эхлэн тайланд дэлгэрэнгүйгээр тооцоо нийлж, баталгаажуулж ирээгүй нь материаллаг хэмжээний алдаатай байх эрсдэлтэй гэж үзэж, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 19.4 хувь, мөнгөн хөрөнгийн 21.1 хувь, нийт зардлын 16.3 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Хүний хөгжил сангийн арилжааны банкны үлдэгдэлд 2012-2013 онд хүүхдийн мөнгөнөөс бодсон хүүгийн 5.106.8 мянган төгрөгийг Хүний хөгжил сангийн дансанд бус, улсын төсвийн 90000901, 90080012, 90000707 тоот дансуудад байршуулж бүртгэсэн, Хүний хөгжил сангаас хүүхэд бүрт олгосон дэвтрийн үнэ 150.2 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд орох ёстой байсныг ХХСангийн дансанд үлдэгдлээр тооцож, нийт 5.257.0 мянган төгрөгийн авлага, өр төлбөр үүссэн байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн болон Хүний хөгжил сангийн дансны үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулсан актыг үндэслэн өр, авлагыг залруулж бүртгэх

2. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор Арилжааны банк, Улсын бүртгэлийн газар болон Нийгмийн халамжийн байгууллагын холбогдох хариуцсан мэргэжилтнүүд хүүхдийн мөнгө авах тухай хүсэлт гаргасан баримт бичгийг үндэслэн баталгаажуулж, Монгол банкинд мөнгө гаргах эрхийг өгч байна. Гэтэл санхүүжүүлээд эрх олгосон мөнгөнөөс тайлант жилд нийт 13211 хүүхдийн мөнгө нэр хаяг, байршил, данс эзэмшигчийн нэрийн зөрүүтэйгээс шалтгаалан буцаагдаж, хүндээ эргэж олгосон эсэх нь тодорхойгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхдийн мөнгийг олгохдоо харьяа дүүрэг, орон нутгийн байршлаар нь мэдээллийг тодорхой гаргаж байх. Мөн түүнд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах

3. Санхүүгийн тайлангийн толилуулга, тэмдэглэлийг бүрэн хийхгүй байгаа нь АОУС 700-ын 14 (г)-р зүйлд заасан **“Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга”-ыг** үнэлэх боломжгүй болгох, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэлийг бэлтгэх аргачлалын 5.3-т: **...Жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь зайлшгүй тэмдэглэлтэй байх** гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлийг холбогдох журам болон **УСНББОУС 1- д заасан Санхүүгийн тайлангийн толилуулга** гэсэн стандартын шаардлагын дагуу гаргаж байх

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үзэж, дүгнэх болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн гэж үзэж, Зөрчилгүй дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан болон бусад холбогдох хавсралт хуудсуудыг тус тус хавсаргав.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

САНГИЙН САЙД
Ж.ЭРДЭНЭБАТ ТАНАА

2015.04.24 № 813
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.


Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний хөгжил сангийн төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк



ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН БАГЦЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Мөнгөн хөрөнгө

Асуудал 2

Авлага өр төлбөр

Асуудал 3

Санхүүгийн тайлангийн тодруулга тэмдэглэл

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хүний хөгжил сангийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хүний хөгжил сангийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор Арилжааны банк, Улсын бүртгэлийн газар болон Нийгмийн халамжийн байгууллагын холбогдох хариуцсан мэргэжилтнүүд хүүхдийн мөнгө авах тухай хүсэлт гаргасан баримт бичгийг үндэслэн баталгаажуулж, Монгол банкинд мөнгө гаргах эрхийг өгч байна. Гэтэл санхүүжүүлэхээр эрх олгосон мөнгөнөөс тайлант жилд нийт 13211 хүүхдийн мөнгө нэр хаяг, байршил данс, эзэмшигчийн зөрүүтэйгээс /тодорхойгүй шалтгаанаар /шалтгаалан буцаагдаж, эргэж олгосон эсэх нь тодорхойгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж**Нийгмийн халамжийн ерөнхий газрын даргад:**

Хүүхдийн мөнгийг олгохдоо харьяа дүүрэг, орон нутгийн байршлаар нь мэдээллийг тодорхой гаргах. Мөн түүнд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах;

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгө хагас дутуу илэрхийлэгдэх тодруулга, тэмдэглэлийг бэлтгээгүй байх;

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Авлага, өр төлбөр	Тэргүүлэх ач холбогдол №2
-------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Хүний хөгжил сангийн арилжааны банкны үлдэгдэлд 2012-2013 онд хишиг хувийн мөнгөнөөс бодсон хүүгийн 5.106.8 мянган төгрөгийг Хүний хөгжил дансанд бус, улсын төсвийн 90000901, 90080012, 90000707 тоот дансуудад байршуулж бүртгэсэн, мөн Хүний хөгжил сангийн дэвтрийн үнэ 150.2 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд орох ёстой байсныг ХХСангийн дансанд үлдэгдлээр тооцож, нийт 5.257.0 төгрөгийн авлага, өр төлбөр үүсгэсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн сангийн газрын дарга, Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын дарга нарт:

Улсын төсвийн болон Хүний хөгжил сангийн дансны үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулсан актыг үндэслэн өр, авлагыг залруулж тайланд тусгах;

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэг-дэх, авлага өр төлбөр хийсвэрээр нэмэгдэх, найдваргүй авлага өр төлбөр үүсэх;

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3: Санхүүгийн тайлагналын тодруулга тэмдэглэл	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн тайлангийн толилуулга, тэмдэглэлийг бүрэн хийхгүй байгаа нь АОУС 700-ын 14 (г)-р зүйлд заасан **“Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга”-ыг** үнэлэх боломжгүй болгох, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэлийг бэлтгэх аргачлалын 5.3-т: **...Жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь зайлшгүй тэмдэглэлтэй байх** гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн тодруулга тэмдэглэлийг олон улсын стандартын дагуу илэрхийлээгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн сангийн газрын даргад:

Санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлийг холбогдох журам болон **УСНББОУС 1- д заасан Санхүүгийн тайлангийн толилуулга** гэсэн стандартын шаардлагын дагуу гаргах;

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,441,802,053.52	142,136,245,263.72
МӨНГӨН ХӨРӨНГӨ	512,569,062.57	33,575,488,246.50
Банкинд байгаа бэлэн мөнгө	512,174,112.57	33,575,488,246.50
Төгрөг	512,174,112.57	33,575,488,246.50
Арилжааны банк дахь харилцах	512,174,112.57	33,575,488,246.50
АВЛАГА	929,232,990.95	108,560,757,017.22
Бусад авлага	929,232,990.95	108,560,757,017.22
Байгууллагаас авах авлага	929,232,990.95	108,560,757,017.22
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,441,802,053.52	142,136,245,263.72
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,024,150,776,499.53	1,124,661,622,868.53
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,024,150,776,499.53	1,124,661,622,868.53
Богино хугацаат үнэт цаас	446,519,487,358.00	479,517,407,358.00
Төгрөг	260,673,407,358.00	262,700,000,000.00
Бонд	260,673,407,358.00	262,700,000,000.00
Гадаад валют	185,846,080,000.00	216,817,407,358.00
Бонд	190,824,100,000.00	216,844,000,000.00
Бондын хөнгөлөлт	-4,978,020,000.00	-26,592,642.00
Өглөг	5,955,819,033.90	335,423,945,698.82
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	48,479,667,550.96
Бусад өглөг	5,955,819,033.90	286,944,278,147.86
Байгууллагад төлөх өглөг	5,955,819,033.90	286,944,278,147.86
Урьдчилж орсон орлого	571,675,470,107.63	309,720,269,811.71
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	571,675,470,107.63	309,720,269,811.71
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-1,022,708,974,446.01	-982,525,377,604.81
Засгийн газрын хувь оролцоо	-1,022,708,974,446.01	-982,525,377,604.81
Хуримтлагдсан үр дүн	-1,022,708,974,446.01	-982,525,377,604.81
Өмнөх үеийн үр дүн	-1,053,034,841,307.40	-1,060,003,192,693.66
Тайлант үеийн үр дүн	30,325,866,861.39	77,477,815,088.85
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,441,802,053.52	142,136,245,263.72

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	399,014,093,817.22	419,061,645,603.64
ТАТВАРЫН ОРЛОГО	325,038,922,100.57	404,024,269,887.31
Бусад татвар (Төлбөр, хураамж)	325,038,922,100.57	404,024,269,887.31
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	195,884,863,019.84	287,913,933,164.50
Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	129,154,059,080.73	116,110,336,722.81
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,978,446,800.09	15,037,375,716.33
Өмчийн орлого	68,978,446,800.09	15,037,375,716.33
Хувьцааны ногдол ашиг	68,305,626,894.08	15,000,000,000.00
Хүү, торгуулийн орлого	290,182,557.45	0.00
Бусад орлого	382,637,348.56	37,375,716.33
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,996,724,916.56	0.00
Улсын төсвөөс	4,996,724,916.56	0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	4,996,724,916.56	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	284,371,066,955.83	291,450,347,701.94
УРСГАЛ ЗАРДАЛ	284,371,066,955.83	291,450,347,701.94
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,942.97	220,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	239,942.97	220,000.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	239,942.97	220,000.00
ХҮҮ	13,558,403,561.64	40,984,827,701.94
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	13,558,403,561.64	40,984,827,701.94
Улсын зээллэг бондын хүү	13,558,403,561.64	40,984,827,701.94
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,083,653,263.16	12,033,200,000.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг	12,151,500,000.00	12,033,200,000.00
ЭМД-ын хураамжаас Эмнэлэгүүдэд өгөх шилжүүлэг	12,151,500,000.00	12,033,200,000.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,932,153,263.16	0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	9,932,153,263.16	0.00
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ - SOCIAL BENEFITS	248,728,770,188.06	238,432,100,000.00
Нийгмийн халамжийн үйлчилгээ	248,728,770,188.06	238,432,100,000.00
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	248,728,770,188.06	238,432,100,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	114,643,026,861.39	127,611,297,901.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	84,317,160,000.00	50,133,482,812.85
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	84,317,160,000.00	50,133,482,812.85
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	30,325,866,861.39	77,477,815,088.85

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	388,969,195,556.68	730,005,754,075.91
ТАТВАРЫН ОРЛОГО	310,223,837,518.35	296,387,973,341.57
Бусад татвар (Төлбөр, хураамж)	310,223,837,518.35	296,387,973,341.57
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	181,091,743,225.41	183,844,849,218.76
Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	129,132,094,292.94	112,543,124,122.81
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,791,695,229.89	433,617,780,734.34
Өмчийн орлого	68,791,695,229.89	433,617,780,734.34
Хувьцааны ногдол ашиг	68,305,626,894.08	15,000,000,000.00
Хүү, торгуулийн орлого	293,637,986.29	1,722,308,173.97
Төсөвт байгууллагын өөрийн орлого	192,430,349.52	0.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	192,430,349.52	0.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,953,662,808.44	0.00
Улсын төвлөрсөн төсвөөс	190,409,999.04	0.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	190,409,999.04	0.00
Төсвийн захирагчдаас	9,763,252,809.40	0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	9,763,252,809.40	0.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	601,713,691,466.15	556,075,634,891.98
УРСГАЛ ЗАРДАЛ	601,713,691,466.15	556,075,634,891.98
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,259,270,314.29	423,029.35
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,569,311,549.94	220,000.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	239,942.97	220,000.00
Төлбөр хураамж болон бусад зардал	256,569,071,606.97	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	56,689,958,764.35	203,029.35
Урьд оны өр	56,689,958,764.35	203,029.35
ХҮҮ	8,580,383,561.64	295,609,911,862.63
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	8,580,383,561.64	295,609,911,862.63
Улсын зээллэг бондын хүү	8,580,383,561.64	295,609,911,862.63
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,931,981,604.22	10,000,000,000.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,931,981,604.22	10,000,000,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	9,931,981,604.22	0.00
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ - SOCIAL BENEFITS	269,942,055,986.00	250,465,300,000.00
Нийгмийн халамжийн үйлчилгээ	257,790,555,986.00	238,432,100,000.00
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	253,578,716,320.00	238,432,100,000.00
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	4,211,839,666.00	0.00

Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг	12,151,500,000.00	12,033,200,000.00
Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн хураамж	12,151,500,000.00	12,033,200,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-212,744,495,909.47	173,930,119,183.93
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	204,142,478,964.97	-140,867,200,000.00
Авсан зээл	204,142,478,964.97	
		-140,867,200,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-8,602,016,944.50	33,062,919,183.93
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,114,586,007.07	512,569,062.57
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	512,569,062.57	33,575,488,246.50

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
Үлдэгдэл	0.00	0.00	1,057,810,641,302.60	1,057,810,641,302.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,775,799,995.20	4,775,799,995.20
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,053,034,841,307.40	1,053,034,841,307.40
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	30,325,866,861.39	30,325,866,861.39
Үлдэгдэл	0.00	0.00	1,022,708,974,446.01	1,022,708,974,446.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-37,294,218,247.65	-37,294,218,247.65
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,060,003,192,693.66	1,060,003,192,693.66
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	77,477,815,088.85	77,477,815,088.85
2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	-982,525,377,604.81	-982,525,377,604.81

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВ	ТАЙЛАНТ ОН	ЗӨРҮҮ	ХУВЬ
НИЙТ ДҮН	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	318,498,000,000.00	312,490,227,737.27	6,007,772,262.73	98.11
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	318,498,000,000.00	312,490,227,737.27	6,007,772,262.73	98.11
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	313,077,700,000.00	312,490,227,737.27	587,472,262.73	99.81
Бараа, Үйлчилгээний зардал	-	220,000.00	(220,000.00)	
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	-	220,000.00	(220,000.00)	
Бараа, Үйлчилгээний бусад зардал	-	220,000.00	(220,000.00)	
Банкны Үйлчилгээний хураамж	-	220,000.00	(220,000.00)	
Зээлийн Үйлчилгээ \хүү\	62,044,500,000.00	62,024,947,737.27	19,552,262.73	99.97
Дотоодын зээлийн хүү	62,044,500,000.00	62,024,947,737.27	19,552,262.73	99.97
Улсын зээллэгээ-бондын хүү	62,044,500,000.00	62,024,947,737.27	19,552,262.73	99.97
Банкны зээлийн ХҮҮгийн телбөр	-	-	-	
Татаас ба урсгал шилжүүлэг	251,033,200,000.00	250,465,060,000.00	568,140,000.00	99.77
Засгийн газар хоорондын шилжүүлэг	12,033,200,000.00	12,033,200,000.00	-	100.00
Төсөв хоорондын урсгал шилжүүлэг	12,033,200,000.00	12,033,200,000.00	-	100.00
Төр хариуцах иргэдийн хураамж	12,033,200,000.00	12,033,200,000.00	-	100.00
Ерх гэрт олгох шилжүүлэг	239,000,000,000.00	238,431,860,000.00	568,140,000.00	99.76
Нийгмийн халамжийн зардал	239,000,000,000.00	238,431,860,000.00	568,140,000.00	99.76
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	239,000,000,000.00	238,431,860,000.00	568,140,000.00	99.76
Хүн амын тодорхой бүлэгт үзүүлэх дэмжлэг	-		-	
Иргэнд хҮртээх хишиг хувь	-		-	
V. ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ДҮН	5,420,300,000.00	-	5,420,300,000.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	549,780,023,854.89	419,024,269,887.31	130,755,753,967.58	76.22
Туслах Үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	
Хүүгийн орлого	-	-	-	
Ашигт малтмалын нөөц ашигласны телбөр	339,892,467,004.89	287,913,933,164.50	51,978,533,840.39	84.71
Ёсөн нэмэгдэх нөөц ашигласны телбөр	194,887,556,850.00	116,110,336,722.81	78,777,220,127.19	59.58
Ногдол ашиг	15,000,000,000.00	15,000,000,000.00	-	100.00
Төсвөөс санхүүжих	-	-	-	
Мөнгөн хөрөнгийн эхний Үлдэгдэл	-	512,569,062.57		
Мөнгөн хөрөнгийн эцсийн Үлдэгдэл	-	33,575,488,246.51		
Тохируулсан орлого зарлагаас үлдсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	(73,471,122,966.11)		